онцлог, гүйцэтгэх баримт бичгийн тоо, үнийн дүн зэргийг харгалзан эрсдэлийн сангаас нэмж олгодог байх.

3. Төсвийн байгууллагад холбогдох төлбөр, хүүхдийн тэтгэлэг, гэмт хэргийн улмаас бусдад учирсан хохирол, улсын орлогын зардлын мөнгийг урьдчилан төсвөөс гаргаад эргэж төлбөр төлөгчөөс гаргуулдаг болох.

Аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн алба урамшууллын гэрээнээс зардалд суутган авдаг 0,3-3,5 хувийг, шийдвэр гүйцэтгэгч ажиллагааны зардлыг төлбөр авагчтай тус тус байгуулдаг зардлын гэрээ байгуулан авдаг болох. Ингэсэн нөхцөлд шийдвэр гүйцэтгэгчид очих урамшууллын хэмжээ 0,2- 6,5 хүртэлх хувь болж буурна.

Б.ЛХАГВАА

Цагдан хорих 461-р ангийн хүний нөөц, сургалт хариуцсан дэд дарга, ахлах дэслэгч

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Мэдээллийн эрх чөлөө (Свобода информации. Freedom of information). нь мэдээллийг хуулиар зөвшөөрөгдсөн аливаа аргаар эрж хайх, хүлээж авах, дамжуулах, түгээх эрх гэж тодорхойлсон



байдаг.

Мэдээллийн эрх, эрх чөлөөнд:

- Хүн мэдээлэл хүртэх
- Мэдээлэл олж авах
- Мэдээлэл түгээх эрхүүд тус тус багтдаг

Мэдээллийг олж авах эрхийг мэдээлэл хайх, түгээх эрхээс тусгайлан авч үзэх шаардлага урган гарч байна. Тэгвэл мэдээллийг олж авна гэдэг бол мэдээллийг үнэлж дүгнэх, мэдээлэлд

боловсруулалт хийх боломжийг бий болгож байдагт гол утга учир нь оршино. Мэдээлэл хайх эрхийг баталгаажуулах нь мэдээллийн эрх чөлөө, мэдээллийг олж авах боломж баталгааг хангаж буй угтвар нөхцөл болж байдаг. Мэдээлэлийн эх сурвалжыг олж мэдэх, боловсруулах, нийтийн хүртээл болгох гэсэн гурван үе шат дамжлагаар мэдээлэл бий болдог байна.

Нэг. Эхний үе шат буюу мэдээллийг олж мэдэх,

Хоёр. Дараагийн үе шат буюу мэдээг боловсруулах,

Гурав. Эцсийн шат буюу мэдээлэгдэх"[99] гэж ангилан үзсэн байдаг.

Мэдээлэл авах эрхийн талаар манай улсын төдийгүй олон улсын эрх зүйн бичиг баримтанд тодорхой тусгаж түүгээр дамжуулах хэрэгжүүлж ирсэн түүхэн уламжлалтай. Тухайлбал.

Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан амаар бичгээр буюу хэвлэлээр, эсхүл уран сайхны хэлбэрээр болон өөрийн сонгосон аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана" хэмээн Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан байна. Өөрөөр хэлбэл, мэдэх, мэдээлэл авах эрх нь хүний заяамал эрхүүдийн нэг гэж үзэж болно. Нэг үгээр хэлбэл хүн хорвоод мэндлэхдээ л энэхүү эрхтэйгээ хамт ирсэн гэсэн үг. Иргэн та ч гэсэн мэдэх эрхтэй, хүссэн мэдээллээ олж авах эрхтэй гэж үзэж болно.

Монгол улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь заалтанд "Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан бол энэхүү эрхийг "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" Монгол улсын хуулиар баталгаажуулж өгсөн байна. Энэхүү мэдээлэл олж авах, түгээх эрхийг улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх, нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс зөвхөн хуулиар хязгаарлаж болно. Харин Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 2-т "Хүн бүр эрх, эрх чөлөөг эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүй ёсны дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг нийгмийн хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосон хязгаарлалтад захирагдана" гэж заасан байгаа нь хүн хэдий чинээ эрхтэй байна тэр тодорхой хязгаарлалтай байна гэдэг талаас нь тусгаж өгсөн байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль болон, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт мэдээлэл авах эрх нь хорих ял эдлэгсдийн эрх зүйн байдлын хүрээнд ямар агуулгын хүрээнд мэдээлэл авах талаар хуульчилж өгсөн байдаг. Жишээлбэл:

- Ялтан нь шүүхээс оногдуулсан ял, ял эдлэх нөхцөл журам, эрх үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах;
- өөрт холбогдох асуудлаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;
- өмгөөллийн болон хууль зүйн туслалцаа авах;
- төрөл, садантайгаа удаан, бусад хүнтэй түр хугацаагаар уулзах, утас, захидлаар харилцах, илгээмж авах;
- сонин, сэтгүүл захиалах, ном унших;
- хорих байгууллагын номын санг ашиглах гэх мэтээр мэдээлэл авах эрхүүдтэй байдаг.

Харин "Гадаад улсын харьяат иргэд нь дээрх эрхээс гадна гадаад

[99] Б.Цогням. Мэдээллийн харилцааг хуульчилан зохицуулах шаардлага., "Эрх зүй" сэтгүүл,8-9/2002

хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан газар нэгжээр дамжуулан өөрийнхөө орны дипломат төлөөлөгчдийн газрын ажилтантай уулзаж, харилцах эрхтэй" хэмээн заажээ.

Иргэд болон хорих ял эдлэгсдийн мэдээлэл авах эрхийн талаар хууль эрх зүйн бичиг баримтанд тодорхой тусгалаа олон хэрэгжиж байгаа хэдий ч эрхээ хязгаарлуулсан хорих ял эдэлэгсдийн тухайд хязгаарлуулсан эрхээ бүрэн авч чадахгүй байгаа хорих ял эдэлж байгаа 203 ялтнаас авсан судалгаанаас харагдаж байгаа юм.

Тэгвэл хорих байгууллагын ажилтнууд ялтан болон түүний гэр бүлийн гишүүдэд ямар мэдээлэл дамжуулах эрх, үүрэгтэй вэ гэсэн асуулт байгаа юм. Үүнийг авч үзье: /Хүснэгт-1/

Ял эдлэж байгаа ялтнууд нь мэдээллийн хэрэгцээгээр хэрхэн хангагдаж байгаа талаар хорих ял эдлэж байгаа 203 ялтнаас авсан судалгааны дүгнэлтийг авч үзье:













Дээрх графикаас харахад мэдээллийн төрөл, хэлбэр, мэдээллийн суваг, түүний ач холбогдолын талаар хорих ял эдлэгсэд хууль эрх зүйн хүрээндзаагдсан эрхүүдийн талаар хангалттай мэдээлэлтэй байгаа, мэдээлэл авах хэрэгцээ их байгаа нь ажиглагдаж байна. Иймээс заагдсан эрхийн хүрээнд хорих ял эдлэгсдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах нь шаардлагатай байна.

Хорих ангийн нийгмийн ажилтнуудаас авсан судалгаанд хорих ял эдлэгсэд нь ямар мэдээллийг илүү авах хүсэлтэй байдаг талаар судалгаа авахад хорих ялын хугацаа, цалин, хөдөлмөрийн хөлс, эрх үүрэг, шинээр гарч буй хуулийн өөрчлөлтүүд гэх мэт мэдээллийг байнга тогтмол авах хүсэлтэй байдаг талаар дурьджээ.

Хүн бүрийн мэдээлэл авах хэрэгцээг бүрэн хангана гэж үзвэл боломжгүй, хүний мэдээллийн хэрэгцээ хязгааргүй тийм ч учраас тогтоосон хууль тогтоомж, журам зааврын хүрээнд заагдсан мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

ДҮГНЭЛТ

Мэдээлэл техник технологийн эрин зуун хэмээн нэрлэгдэж буй өнөө үед мэдээллийн хэрэгцээ, хурд асар ихээр нэмэгдэж, түүнийг дамжуулах түгээх арга хэрэгслүүд улам боловсронгуй болж өргөжин тэлсээр байгаа энэ цаг үед хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг хорих ял эдлэгсдэд хурдан шуурхай хүргэх нь тэднийг гадаад ертөнцтэй харилцах, мэдээллийг дамжуулах нь тэднийг нийгэмшүүлэх гол арга хэрэгсэл болох юм.

Хэрэгцээт мэдээллийг олж авах нь хорих ял эдлэгсдийн гадаад орчин, нийгмийн амьдралд дасан зохицох чадварыг нэмэгдүүлж улмаар суллагдаж гарахдаа улс нийгмийн талаар өөрийн үзэл бодолтой болох, нийгмийн хөгжлөөс хоцрохгүй зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Хорих ял эдлэгсдийн мэдээлэл олж авах эрхийн эрх зүйн зоихцуулалтыг сайжруулж хорих ял эдлэгсдэд ямар мэдээлэл олж авах, ямар мэдээлэл хязгаарлагдмал байх талаар тодорхой тусгаж тэдний мэдээлэл авах эрхийг хангах, мэдээлэл авах хэрэгслүүдийг орчин үеийн дэвшилтэд техник технологийн аргаар түгээх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Санал:

Хорих ял эдлэгсдийн мэдээлэл авах эрхийг эрх зүйн зохицуулалтанд тодорхой тусгаж өгөх.

Хорих ял эдлэгсдийн мэдээлэл авах хүсэлт хэрэгцээнд тулгуурлан судалгаа дүн шинжилгээ хийж тэдгээр зориулсан гарын авлага ном товхимол гаргах

Хорих ял эдлэгсдэд шаардлагатай мэдээллийг хурдан шуурхай хүргэх зорилгоор тэдгээрт зориулсан мэдээлэл лавлагааны утас ажиллуулах

Ял эдлэх хугацааны өөрт холбогдолтой мэдээллийг хүссэн үедээ авч болохуйц цахим машин ажиллуулах